

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

Орхон аймгийн Эрүүл мэндийн газар

2025 оны 12 дугаар сарын 02

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1.1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар байгууллагын цахим хуудас www.or.mohs.gov.mn болон мэдээллийн самбарт ил тодоор байршуулан, тухай бүр шинэчилсэн. Эрүүл мэндийн байгууллагын 2025-2028 оны Стратеги төлөвлөгөө 9 бүлгийн хүрээнд байгууллагын тулгамдсан асуудал, статистик тоон үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, нийтлэг, салбарт мөрдөгдөх 60 хууль, мандатын шинжилгээнд ерөнхий чиг үүрэг -1, үндсэн чиг зэрэг-6, SWOT шинжилгээнд давуу тал-18, сул тал-15, боломж -7, эрсдэл-6-г тодорхойлж, , PESTEL анализын аргаар хууль эрх зүйн чиглэлээр 9, нийгэм, эдийн засгийн чиглэлээр 17, гадаад харилцаа, түншлэлээр 11, технологийн чиглэлээр 15 давуу сул талуудыг тогтоож, 12 шалгуур үзүүлэлт болон 13 зорилтын хүрээнд 47 ажлыг хийхээр төлөвлөгөөг 2024 оны үзүүлэлтийг суурь түвшин болгож, 4 жилээр шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц тоо болон чанарын үзүүлэлтээр гаргаж батлуулсан.Стратеги төлөвлөгөөнд Эрүүл мэндийн газрын эрхэм зорилго, зорилтуудыг шинэчлэн гаргаж 2025 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 95.6%-тай хэрэгжсэн. Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй бодлого зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төрийн үйлчилгээ үзүүлж байгаа ажил хариуцсан албан хаагчдын овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, харилцах утас зэрэг мэдээллийг шинэчлэн байгууллагын цахим хуудас, төрийн албан хэрэг хөтлөх И оффис программд болон байгууллагуудын мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байршуулсан. Эрүүл мэндийн газар /www.or.mohs.gov.mn/ , Бүсийн оношилгоо эмчилгээний төв /www.orkhonboet.moh.gov.mn/ зэрэг байгууллагууд байгууллагын вэб сайттай бөгөөд бусад эрүүл мэндийн байгууллагууд facebook page хуудас ажиллуулан мэдээллийг иргэдэд хүргэн ажилласан. Орхон аймгийн Эрүүл мэндийн газар Facebook page хуудсыг тогтмол ажиллуулж иргэдэд эмнэлгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэж ажилласан бөгөөд тус page хуудсыг 19000 хүн дагаж байна.	100
1.2	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	Аймгийн Засаг даргын 2023 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн А/84 дүгээр захирамжаар Эрүүл мэндийн газрын бүтэц, орон тоо, үйл ажиллагааны чиг үүргийг шинэчлэн баталсан. Шинэчлэгдсэн бүтэц, чиг үүргийг байгууллагын цахим хуудас www.or.mohs.gov.mn болон нийгмийн сүлжээний facebook хуудсанд ил тодоор байршуулсан. Мөн байгууллагын хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн	100

		<p>хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаягийг www.or.mohs.gov.mn цахим хуудаст ил тодоор байршуулсан. Үүнээс гадна дээрх мэдээллүүдийг байгууллагын үүдэнд байрлах мэдээллийн самбарт нээлттэй байрлуулж, ирсэн санал өргөдөл гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэж хариу өгч ажилласан.</p>	
1.3	<p>Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;</p>	<p>Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт, статистик үзүүлэлтэд дүн шинжилгээ хийн сар, улирлаар гарган анхан шатны эрүүл мэндийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудын цахим систем, Эрүүл мэндийн газрын вэб сайтад ил тод байршуулсан. Эрүүл мэндийн салбарын удирдлагын шуурхайд улирал тутам статистик үзүүлэлтийг танилцуулан эргэн мэдээллээр ханган ажилласан.</p> <p>Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт, статистик үзүүлэлтэд дүн шинжилгээ хийн сар, улирлаар гарган анхан шатны эрүүл мэндийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудын цахим систем, Эрүүл мэндийн газрын вэб сайтад ил тод байршуулсан. Эрүүл мэндийн салбарын удирдлагын шуурхайд улирал тутам статистик үзүүлэлтийг танилцуулан эргэн мэдээллээр ханган ажилласан.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу Эрүүл мэндийн газраас нэгтгэгдэн гарч буй хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон бодлогын баримт бичгийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх явцад албан хаагчдыг зөвлөмжөөр ханган тайланд тухай бүр сайжруулалт хийж, илтгэх хуудас, зөвлөмжийг албан хаагч тус бүрд хүргэн ажилласан. Нийт 25 тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдсэн. Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийсэн тухай Эрүүл мэндийн газрын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, тайланг Эрүүл мэндийн яам болон аймгийн Засаг даргын тамгын газарт албан тоотоор хугацаанд нь хүргүүлсэн. Байгууллагын Дотоод хяналтын багийн 2025 оны төлөвлөгөөг батлуулан ажиллаж, тайлант хугацаанд төлөвлөгөөт 4, төлөвлөгөөт бус 2 нийт 6 хяналтыг хийж хяналтын дүгнэлтийг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох эрүүл мэндийн салбар, албан хаагчдад хяналтын дүнг танилцуулан зөвлөмжөөр ханган ажилласан.</p> <p>Төрийн аудитын газраас 2024 оны санхүүгийн тайланд хяналт, шалгалт хийгдэж, Төрийн аудитын газраас ирүүлсэн аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын тайланг аудитын тайлангийн хамт шилэн дансны нэгдсэн системд бүрэн тайлагнасан</p>	100
1.4	<p>Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;</p>	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний талаар мэдээллийг цахим хуудас болон самбарт шинэчлэн байршуулж</p>	100

		сурталчилсан. ЭМЯ, аймгийн Засаг даргын тамгын газраас Эрүүл мэндийн газрын 2024 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ирүүлсэн зөвлөмжийн дагуу байгууллагын гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөг батлуулан, цахим хуудаст байршуулан хэрэгжүүлэн ажилласан. Эрүүл мэндийн байгууллагуудад цахим мэдээллийн аюулгүй байдлын тухай багц хуулиудын сургалтыг эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага, мэргэжилтнүүдэд 2 удаа, эрүүл мэндийн байгууллагууд дотооддоо сургалтууд зохион байгуулж нийт давхардсан тоогоор 675 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тайланг гаргаж И оффис цахим мэдээллийн санд оруулсан.	
1.5	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг цаг хугацаанд нь ЭМГ-ын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүргүүлсэн. Үүнд: - Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн салбартай хамааралтай 27 арга хэмжээний хүрээнд хийгдсэн арга хэмжээний 2025 оны хэрэгжилт дунджаар 92,1%-тай / үр дүнд хүрсэн/ үнэлэгдсэн. - Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний эрүүл мэндийн салбартай хамааралтай 11 арга хэмжээний 2025 оны хэрэгжилт дунджаар 96,3%-тай үнэлэгдсэн. Тус бодлогын зорилтыг хэрэгжүүлэхээр батлагдсан Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 15 заалтын хэрэгжилт 93,3%, Орхон аймгийн хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт 94,2%, Орхон аймаг, Эрдэнэт хотын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт 95,8% дүгнэгдсэн.	100
1.6	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	Тайлант хугацаанд Засгийн газрын тогтоол 2, Эрүүл мэндийн сайдын тушаал 43, аймгийн Засаг даргын захирамж 28, Эрүүл мэндийн газрын даргын А тушаал 111, Б тушаал 43 батлагдсаныг Эрүүл мэндийн газрын www.or.mohs.gov.mn цахим хуудаст байршуулж, салбар байгууллагуудад хүргүүлж сурталчлан хэрэгжилтийг ханган ажилласан. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хүрээнд 21 хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг 2025 оны байдлаар дүгнэж төрийн албан хэрэг хөтлөлтийн И оффис программд оруулж, байршуулсан. Хэрэгжилт дунджаар 90%-тай үнэлэгдсэн. Хүчингүй болсон, хяналтаас хасуулах заалт байхгүй байна. Хэрэгжилтийг ЭМГ-ын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох газруудад хүргүүлэн ажилласан.	100
1.7	Албан тушаалын тодорхойлолт, албан	Эрүүл мэндийн газрын төрийн үйлчилгээ үзүүлж байгаа албан хаагчдын овог, нэр,	100

	<p>тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;</p>	<p>албан тушаал, албан тушаалын тодорхойлолт, албаны харилцах утас, цахим шуудангийн хаягийн мэдээллүүдийг байгууллагын www.or.mohs.gov.mn цахим хуудас, Эрүүл мэндийн газар болон Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Жаргалант сумын эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйлчилгээ үзүүлж байгаа албан хаагчдын овог, нэр, албан тушаал, өрөөний дугаар, харилцах утас, цахим шуудангийн хаягийн мэдээллүүдийг төрийн албан хэрэг хөтлөх И-оффис программ, аймгийн ЗДТГ-ын erdenet.mn цахим хуудасны лавлагаа мэдээлэл болон байгууллагын мэдээллийн цахим хуудаст ил тод нээлттэй байршуулсан. Мөн албан хаагчдын зураг бүхий танилцуулгын самбарыг ил тод байршуулсан.</p>	
1.8	<p>Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;</p>	<p>Байгууллагын өргөдөл гомдол хариуцсан албан хаагчийг томилон ажиллуулж мэдээлэл болон холбоо барих утасны дугаар, өрөөний дугаар болон иргэдээс мэдээлэл, санал, хүсэлт, талархал, гомдол авах цагийн хуваарийг байгууллагын or.mohs.gov.mn цахим хуудасны “Өргөдөл гомдлын шийдвэрлэлт” цэс болон байгууллагын мэдээллийн самбарт ил тод байршуулан мэдээлэл өгч ажилласан.Тайлант хугацаанд 460 албан бичиг хүлээн авч 405 албан бичгийг хүргүүлж, цахим хэлбэрээр солилцон, хяналтад авч хэрэгжилтийг хангасан эсэх, шийдвэрлэлтийн явц байдалд тухай бүрт цахимаар (Able) хянаж ажилласан бөгөөд өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд И-оффис системийн ашиглалт 100% байна. -Өргөдөл гомдол хариуцсан албан хаагчийг томилон ажиллуулж мэдээлэл болон холбоо барих утасны дугаар, өрөөний дугаар болон иргэдээс мэдээлэл, санал, хүсэлт, талархал, гомдол авах цагийн хуваарийг байгууллагын or.mohs.gov.mn цахим хуудасны “Санал гомдол” цэс болон байгууллагын мэдээллийн самбарт ил тод байршуулан мэдээлэл өгч ажилласан.</p>	100
1.9	<p>Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;</p>	<p>Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 тушаалын дагуу эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй 163 байгууллагаас үйл ажиллагааны чиглэлээр сар бүр албан ёсны мэдээ тайланг батлагдсан маягтын дагуу 141 үзүүлэлтээр хүлээн авч нэгтгэн , Эрүүл мэндийн хөгжлийн төв болон аймгийн статистик, эрүүл мэндийн байгууллагуудад мэдээлж, байгууллагын цахим хуудас www.or.mohs.gov.mn -д ил тод байршуулсан. Статистик үзүүлэлтэд дүн шинжилгээ хийн анхан шатны эрүүл мэндийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудын цахим системд байршуулан улирлаар брошур гарган мэдээллээр хангасан.Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах Монгол улсын ерөнхийлөгчийн 2024 оны 73 дугаар зарлигийг хэрэгжүүлж орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын цахим эрүүл мэндийн системд холбуулж, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд хүн амын өвчлөл төрөлт нас баралтын мэдээг өдөр тутам мэдээлж ажилласан.Тайлант хугацаанд мэдээ өгөлт</p>	100

		89.1%, мэдээний чанар 96% байна.	
1.10	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.	Тайлант хугацаанд хэмжээнд Аймгийн ИТХ-ын 2024 оны 18/04 дугаар тогтоолоор батлагдсан “Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах 2024–2031 оны хөтөлбөр” болон Засаг даргын 2025 оны А/205 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд ажлын хэсэг 3 удаа, Эрүүл мэндийн газрын дэд баг 4 удаа хуралдаж, нөлөөллийн бүсэд амьдарч буй 1,866 иргэнээс эрсдэл өндөртэй 500 иргэнийг хяналтат үзлэгт хамруулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлсэн. Мөн цагаан тоосны дэгдэлтийн бүс болох Жаргалант сум, Баянцагаан, Говил багийн иргэд болон хүүхдийн байгууллагуудад эрүүл мэндийг дэмжих 6 төрлийн өртөөт өдөрлөгийг 9 удаа зохион байгуулж, нийт 1,510 иргэнийг хамруулсан. Цагаан тоосны нөлөөлөл болон түүнээс урьдчилан сэргийлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр хяналт, үзлэг, сургалт, мэдээлэл түгээх бүх төрлийн арга хэмжээнд нийт 400 сая төгрөгийн санхүүжилт зарцуулсан.	80
Хэсгийн дундаж хувь- 98,0%			
Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод байдал			
2.1	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	Төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэл тогтмол хөтөлж ажилласан. Төрийн жинхэнэ албан хаагчийн 9 сул орон тооны мэдээллийг Төрийн албаны салбар зөвлөлд 7 удаа хүргүүлж зарлуулсан бөгөөд шалгалтад орсон иргэдийг мэдээллээр хангаж ажилласнаар 5 төрийн захиргааны албан хаагчийг ажлын байраар хангасан. Мөн ажлын байрны сул орон тооны зарыг www.or.mohs.gov.mn www.orkhonboet.mn , орон нутгийн “Мэдээллийн бирж” телевиз, Эрүүл мэндийн хөгжлийн төв https://hr.hdc.gov.mn/jobList сайтуудад ил тод нээлттэй байршуулж, шаардлагатай 112 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг авч ажиллуулсан.	100
2.2	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	Эрүүл мэндийн байгууллагууд эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байраар хангахдаа Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон байгууллагуудын хөдөлмөрийн дотоод журамд заасан болзол шалгуурын дагуу нээлттэй зохион байгуулж ажилласан. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацаанд сул орон тоог нөхөх 9 албан тушаалын хүсэлтийг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, сул орон тоог нөхөх журмын дагуу сонгон шалгаруулалт зарлаж төрийн албаны нөөцөд бүртгэлтэй 5 хүн төрийн захиргааны албан хаагчийн сонгон шалгаруулалтад тэнцэн мэргэжилтнээр ажилласан. Тайлант хугацаанд эрүүл мэндийн байгууллагуудад 112 ажилтныг шинээр ажлын байраар хангаснаас Эрүүл мэндийн газарт 5 хүн, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 106, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 42, Жаргалант сумын эрүүл мэндийн төвд 5 эмч, эмнэлгийн мэргэжилтэн шинээр ажлын байраар ханган хүний нөөцийн хангалтыг	100

		нэмэгдүүлсэн байна.	
2.3	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	<p>Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбоотой Аймгийн Эрүүл мэндийн газар, БОЭТ, Жаргалант сумын эрүүл мэндийн төвдүүдийн дэргэд Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хороо байгуулагдсан. Мөн Эрүүл мэндийн газрын дэргэд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт 24 удаагийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх кредиттэй болон кредитгүй танхимын сургалтыг зохион байгуулж нийт 951 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.</p> <p>ЭМГ-ын Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны хэрэгжилт 98%-тай байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - ЭМГ-ын албан хаагчдын ажлын байранд тавигдах журмыг батлуулан ТАХ-ын ёс зүйн тухай хууль, ажлын байранд тавигдах шаардлагыг тогтмол сануулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 31 постерийг албан хаагчдад түгээж, ТАХ-ийн ёс зүй манлайллыг нэмэгдүүлэх зорилгоор төрсөн өдөр нь тохиосон 28 албан хаагчид ёс зүйг сануулсан мэндчилгээг хүргэсэн. - “Еннеаграм ба Урлагийн сэтгэл засал”, “Хувь хүний хөгжил” сэтгэл зүйн сургалтыг “Амьдралын зөв хараа” НҮТББ-тай хамтран еннеаграмын тухай ойлголт, 9 төрөлт зан чанарын тодорхойлолт, онцлог харьцаа, хоршлын талаар мэдлэг нэмэгдэж, багаар ажиллах арга барил, урлагийн олон талт дасгалуудыг хийж стрессээ зөв тайлах арга зүйд суралцсан. - Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ЭМГ-ын албан хаагчдын ажлын байранд тавигдах журмаар асуулт хариултын тэмцээнийг 2 үе шаттайгаар зохион байгуулсан. Тус тэмцээнд 18 албан хаагч хамрагдаж төрийн албан хаагчийн ёс зүйн 6 зарчим, салбар зөвлөлийн үйл ажиллагааны чиглэлийн мэдлэг нэмэгдэж ЭМГ-ын албан хаагчдын ажлын байранд тавигдах шаардлага, хориглох зүйлсийн мэдлэг 55%-иар нэмэгдсэн байна. Тэмцээнд тэргүүлсэн 8 албан хаагчийг урамшуулсан. - ЭМГ-ын албан хаагчдаас “Төрийн албан хаагчийн ёс зүйн эрсдлийг тодорхойлох” эрсдлийн үнэлгээгээр ёс зүйн зөрчил эсвэл эрсдэлтэй холбоотой үйлдлийг огт хийдэггүй гэж хариулсан 64,8%, заримдаа 20.4%, ихэнхдээ 14,8% гэсэн хариултыг илгээсэн байна. Судалгааны дүнг тооцоолоход ёс зүйн эрсдэл 25.1% байна гэж дүгнэсэн байна - Шинээр ажилд орсон 5 албан хаагчдад “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” “ЭМГ-ын албан хаагчдын ажлын байранд тавигдах журам” “Хөдөлмөрийн дотоод журам” сэдвүүдээр сургалт хийж ёс зүйн баталгааг гаргуулсан авсан. Мөн эрэгтэй албан хаагчдад “Эмэгтэй албан хаагчидтай хэрхэн харилцах вэ” сэдвийн хүрээнд хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулсан. 	100

		<p>- Ёс зүйн академитай хамтарсан “Ёс зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх багц” сургалтад ЭМГ-ын 24 албан хаагч, БОЭТ-ийн 75 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж чадавхжсан.</p> <p>- ТАЗ-аас зохион байгуулсан “ТАХ-ын ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ” хэлэлцүүлэг, “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал бүсийн зөвлөгөөн”-д 11 албан хаагч хамрагдсан. Тайланд хугацаанд 5 удаагийн танхим 4 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 225 албан хаагч хамрагдсан байна. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “ХҮНДЭЛЬЕ-ЭНЭРЬЕ” ёс зүйн нөлөөллийн аянд Эрүүл мэндийн газар, БОЭТ, Жаргалант сумын эрүүл мэдийн төв нэгдэж 5 удаагийн бичлэгийг цахим хуудсуудад түгээж нийт 7854 иргэний хандалт авсан байна.</p> <p>Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хороонд өргөдөл, гомдол ирээгүй, ёс зүйн алдаа зөрчил илрээгүй байна. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд 3 өргөдөл, гомдол бүртгэгдэж 100% шийдвэрлэсэн байна.</p>	
2.4	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	<p>Аймгийн хэмжээнд 2024 оны байдлаар эрүүл мэндийн салбарт 2073 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд үүнээс 452 их эмч, 507 сувилагч ажилласан. Эрүүл мэндийн салбарын 2022-2026 оны хүний нөөцийн төлөвлөлтийг 2 чиглэлээр төлөвлөж, хангалт 91%-тай байна. 2023-2024 онд төрийн санхүүжилт болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтад 82 эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн суралцсанаас улсын төсвийн санхүүжилтээр 3,2% нь суралцсан. Төлөвлөлтийн дагуу нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмчийн эзлэх хувь 92% болж өмнөх оноос 5 хувиар нэмэгдсэн байна. Байгууллагын вэб сайтын ил тод цэсэд хүний нөөц хэсэгт ажлын байрны талаарх мэдээлэл, сул ажлын байрны зар болон хүний нөөцийн сургалт, хөгжил, нийгмийн баталгааг хангах, албан хаагчдын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр гарсан тушаал шийдвэр, дүрэм, журмыг байршуулан, тухай бүр шинэчлэн ил тод байдлыг ханган ажилласан. Хүний нөөцийн удирдлагын систем хөтлөлтийг сайжруулж, тухай бүр шинэчлэн ажилласан. Төрийн албан хаагчдыг ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар хангах хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлсэн.</p> <p>Эрүүл мэндийн ажилчдын нийгмийн баталгааг дэмжих чиглэлээр аймгийн Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 08 дугаар тогтоолоор 2021-2024 онд хэрэгжих “Эмч хөтөлбөрийг батлуулан, тайлант хугацаанд орон нутгийн төсвөөс 150.0 сая төгрөгийг шийдвэрлүүлэн, хэрэгжүүлж, хөтөлбөрийн хэрэгжилт 98,7 хувьтай байна. Тус хөтөлбөрийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан ажилласан.</p>	100
2.5	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	<p>Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, эрх зүйн баримт бичгүүд, орон нутаг, байгууллагаас гарсан шийдвэрийг цахим хуудас, мэдээллийн самбарт тогтмол байршуулан мэдээлж ажилласан.</p> <p>Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтэц, орон тоог Аймгийн Засаг</p>	70

		даргын 2023 оны өдрийн А/84 дугаар захирамжаар 41 орон тоотой батлагдаж, тайлант хугацаанд төрийн захиргааны албан хаагч 22, төрийн үйлчилгээний албан хаагч 10 нийт 32 албан хаагч ажилласан. Бүтэц, орон тооны батлагдсан тушаалыг Эрүүл мэндийн газар цахим хуудаст байршуулсан. Удирдах албан тушаалтнуудыг захиргааны зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд нээлттэйгээр байгууллагын вэб сайтад байршуулан ажилласан.	
2.6	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын дагуу эрүүл мэндийн салбарын төрийн захиргааны албан хаагчдын цалин 12%, Засгийн газрын 2022 оны 489 дугаар тогтоолоор орон нутагт ажилласны нэмэгдэл 20%, 2022 оны 491 дугаар тогтоолоор төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 11/04 тогтоолоор орон нутгийн нэмэгдэл 40% тус тус олгосон. Аймгийн Засаг даргын 2025 оны А/07, Б/422 дугаар захирамжийн дагуу Эрүүл мэндийн газрын 6 мэргэжилтэнд төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвийг журмын дагуу нэмэгдүүлсэн. Эрүүл мэндийн байгууллага бүр албан хаагчдын үр дүнг сар бүр үнэлж, урамшууллыг улирал тутам олгож ажилласан.Цалин, шагнал урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь 72,9%-ийг эзлэж байна.Тайлант хугацаанд цалин шагнал урамшуулалд Бүсийн оношилгоо эмчилгээний төв 75.7%, Жаргалант сумын эрүүл мэндийн төв нь 62,9%-ийг, Эрүүл мэндийн газар нь 74,5%-ыг тус тус зарцуулсан бөгөөд төрийн байгууллагын цалин шагнал урамшуулалд байгууллагын нийт төсвийн дунджаар 71,0%-ийг зарцуулсан байна.Тайлант хугацаанд Төрийн болон Эрүүл мэндийн яам, орон нутгийн шагналд 206, Сувилахуйн нийгэмлэг, Монголын залуучуудын холбоо, Үйлдвэрчний эвлэлийн шагнал-27 нийт 233 эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад ажилчдыг шагнаж урамшуулсан нь өмнөх оны мөнн үеэс 2,1%-иар нэмэгдсэн байна. Аймгийн эрүүл мэндийн салбарын онцлох алдартанаар 1 эмч шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан. Урамшуулал, шагналын талаарх мэдээллийг тухай бүр www.or.mohs.gov.mn цахим хуудсанд байршуулан ил тод байдлыг ханган ажилласан.	100
Хэсгийн дундаж хувь-95,0%			
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх			
3.1.	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	Шилэн дансны хуулийн дагуу 2025 оны төсвийн гүйцэтгэл болон 2025 оны эхний 12 сарын төсвийн гүйцэтгэл, 2025 оны төсвийн төсөөллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн системд бүрэн байршуулсан.	100

3.2.	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	2024 оны 4-р улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн Эрүүл мэндийн яаманд 2025 оны 03 дугаар сарын 17-21-ны дотор бүрэн тайлагнасан. 2025 оны хагас жилийн санхүүгийн тайлан болон 3-р улирлын сайнхүүгийн тайлангийн нэгтгэлийг хуулинд заасан хугацааны дагуу төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгааныг тайлбарын хамт Эрүүл мэндийн яамны нэгтгэлийн тайланд бүрэн нэгтгүүлсэн.	100
3.3.	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	Төсвийн тухай хуульд заасны дагуу Эрүүл мэндийн газар болон эрүүл мэндийн салбар байгууллагуудын нэгтгэсэн санхүүгийн тайланг 2025 оны 01 дүгээр сарын 25-ны дотор Төрийн Аудитад хүлээлгэн өгч 2025 оны 02 дугаар сарын 25-ны дотор аудитын дүгнэлтийг гаргуулан, 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчид холбогдох баримт материал, Төрийн аудитын дүгнэлтийн хамт 2025 оны 03 дугаар сарын 17-21-ны өдрүүдэд нэгтгүүлсэн. Мөн шилэн дансны нэгдсэн системд дүгнэлтийг бүрэн эхээр нь байршуулсан.	100
3.4.	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	ЭМДҮЗ-ын тогтоол, төлбөртэй тусламж үйлчилгээний журмын шинэчлэлт жагсаалтыг shilendans.gov.mn цахим хуудас болон www.orkhonboet.moh.gov.mn хуудас, самбарт байршуулсан. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах, хаяг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг www.or.mohs.gov.mn сайтын Тусгай зөвшөөрөл цэсэд нээлттэй байршуулсан. Тайлант хугацаанд 2026 оноос тусгай зөвшөөрөл бүхий байгууллагууд Etax програмаар дамжуулан license.mn цахим хаягт нэвтрэх бүх хүсэлтийг програмаар шийдвэрлэхээр бэлтгэл ажлыг ханган ажилласан. Улсын тэмдэгтийн хураамжийг аж ахуйн нэгж байгууллагууд Etax програмаар төлбөрийн мэдээлэл үүсгэж төлөлтийг хийсэн. Худалдаанд байгаа эмийн үнийг иргэдэд ил тод нээлттэй цахим хаяг em.hdc.gov.mn Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй нийтийн үйлчилгээтэй 2,830 эмийн сангийн хаяг болон зайлшгүй шаардлагатай эмийн 30 бүлгийн 120 нэр төрлийн 480 нэрийн эмийн үнэ эмийн сангуудад худалдаалж буй үнийн мэдээлэл харагдахуйц байршуулсан байдаг. Эрүүл мэндийн даатгалын үндэсний шинэчлэн батлагдсан тогтоолыг хэвлэмэл нэг төрлийн самбараар эмийн үнийг иргэдэд харагдахуйцаар байршуулан мэдээлэл өгч ажилласан	100
3.5.	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	2025 оны эхний 12 сарын байдлаар батлагдсан төсвийн хуваарийн дагуу сар бүр төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг тайлбарын хамт шилэн дансны нэгдсэн систем болон байгууллагын цахим хаягаар дамжуулан нийтэд ил тодоор мэдээлэн нийт давхардсан тоогоор 12 удаа мэдээлсэн байна.	70
3.6.	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ,	2025 оны эхний 12 сарын байдлаар батлагдсан төсвийн хуваарийн дагуу 5 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй худалдан авалтыг зардлын зүйл батлагдсан төсөв, гүйцэтгэлийн төсвийг өссөн дүнгээр 9 байгууллага, 13 нэр төрлийн ажил үйлчилгээгээр	100

	нийлүүлэгчийн нэр, хаяг;	нийт 557,9 сая төгрөгийн гүйцэтгэлийг авч гэрээний нийт дүн, нийлүүлэгч байгууллага, хаяг шилэн дансны нэгдсэн систем болон байгууллагын цахим хаягаар дамжуулан нийтэд ил тодоор мэдээлж ажилласан.	
3.7.	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;	2025 оны 12 сарын байдлаар батлагдсан төсөв болон нэмэлт дансаар нийт 49 удаагийн гүйлгээгээр 836,5 сая төгрөгийн орлого, 133 удаагийн гүйлгээгээр 1.928.9 сая төгрөгийн зарлагын гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, олгосон, хүлээн авагчийн нэрийн хамт шилэн дансны нэгдсэн систем болон байгууллагын цахим хаягаар дамжуулан нийтэд ил тодоор мэдээлж ажилласан.	100
3.8.	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	Аймгийн хэмжээнд 2025 онд Бондын зээл тусламжаар хийгдэх саналд Аймгийн Бондын ажлын хэсэгт 3 удаагийн хуралд санал танилцуулагдсан. Эрүүл мэндийн салбарт Барилга, их засварын ажилд 2 ажлыг зөвлөх үйлчилгээнд тусгасан. Мөн 3 чиглэлээр тогног төхөөрөмжүүдийг тусгаж 5,5 тэрбум төгрөг тусгаж Үүнд: 1. Зүрх судасны төвийг байгуулах, 2. Пренаталогийн төв байгуулах /тоног төхөөрөмжийн зардал /Нярайн гажиг хөгжлийг оношилох төв, тоног төхөөрөмж, 3. Нийгмийн эрүүл мэндийн сургалтын хэрэглэгдэхүүн, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, төсөл хөтөлбөрт 2 чиглэлийн 3,4 тэрбум төгрөгийг тус тус тусган ажиллаж байна. 2025 онд Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 5,0 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдаж 100 хувь ажил үйлчилгээ хийгдэж, нийлүүлэгдэн үйл ажиллагаандаа ашиглагдаж байна. Эрүүл мэндийн газрын 2025 оны 12 сарын байдлаар нийт бараа материал хуваарилах, үндсэн хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой 11 тушаалаар нийт 325,1 сая төгрөг, 49 тушаал шийдвэрээр 2.617.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө зарцуулахтай холбоотой тушаалыг шилэн дансны нэгдсэн систем болон байгууллагын цахим хаягаар дамжуулан нийтэд ил тодоор мэдээлж ажилласан.	100
3.9.	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	Шилэн дансны тухай хуульд заасны дагуу 2025 оны 12 сарын байдлаар заавал байршуулах 5 талбарын 166 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулан олон нийтэд мэдээлсэн ба байгууллагын санхүүгийн ил тод байдлын самбар, байгууллагын цахим хуудаст бүрэн байршуулсан. 5 мэдээллийн хуулийн хугацаа нь болоогүй байна. Мөн 2024 оны санхүүгийн тайлангаар өгсөн Төрийн аудитын газраас ирүүлсэн аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын тайланг аудитын тайлангийн хамт шилэн дансны нэгдсэн системд бүрэн тайлагнасан.	70
3.10.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжихаар батлагдсан ажлуудыг Аймгийн Худалдан авах ажиллагааны газар болон Баян-Өндөр сумын худалдан авах ажиллагааны газраас нээлттэй тендерийг хууль журмийн дагуу зарлагдан компани шалгаруулалт нь амжилттай болж эрүүл мэндийн салбарт 100 хувь нийлүүлэгдэн, үйл	100

	журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан	ажиллагаандаа ашиглаж хэвийн явагдаж байна.	
3.11.	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт;	2025 онд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн худалдан авах ажиллагаанд явцын хяналт шалгалтыг 10 дугаар сараас эхлүүлсэн боловч нэгдсэн дүгнэлт гараагүй байна. 2024 онд Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 7,6 тэрбум төгрөгийн 67 төрлийн худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 282,5 сая төгрөгийн 6 төрлийн худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулсан. Цахим дэлгүүрээс 1,3 тэрбум төгрөгийн батлагдсан төсөвтэй 341 төрлийн барааг 172 удаагийн захиалгаар 1,1 тэрбум төгрөгөөр худалдан авалт хийгдсэн. Төрийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20,1 д “ Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь тайлгналт, зөвлөмжийн хүрээнд хуулийн дагуу үнэн зөв тайлагнасан болно. Уг хяналт шалгалтын дүгнэлтээр ямар нэгэн зөрчил дутагдалгүй гэсэн дүгнэлт гарсан.	100
3.12.	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;	-	-
3.13.	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2025 оны худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим сайт болох tender.gov.mn сайтад батлагдсан төлөвлөгөөний дагуу зарласан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хэмжээнд нээлттэй тендер 5, харьцуулалтын аргаар 4 тендер тус тус зарласан. Тайлант хугацаанд санал гомдол 1 гарсан. Тус гомдолыг журам зааврын дагуу холбогдох яам, монополын эсрэг газарт мэдэгдэж шийдвэрлэсэн болно. Нээлттэй тендер- эм эмнэлгийн хэрэгсэлийг 70 багцад 3,265,000,000 төгрөгт, Хүнсний материал нийлүүлэх тендерийг 2 багцад 260,000,000 төгрөгт, шатах тослох материал нийлүүлэх тендерийг 140,000,000 төгрөгт, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар мэс заслын иж бүрэн вакум өрөөний ажил тендерт 1,400,000,000 төгрөгт, эмгэг судлалын тоног төхөөрөмж худалдан авах тендерт 773,480,000 төгрөгт тус тус төсөвт өртөгтэй амжилттай зарласан. Харьцуулалтын аргаар 4 тендерийг - бичиг хэргийн материал нийлүүлэх тендерийг 30,000,000 төгрөгт, улсын хэвлэл мэдээллийн маягт хэвлэх,	70

		бэлтгэх тендерийг 38,000,000 төгрөгт, цэвэрлэгээний материал нийлүүлэх тендерийг 96,000,000 төгрөгт, өндөр өртөгтэй тоног төхөөрөмжийн урсгал засварын тендерийг 80,000,000 төгрөгт тус тус зарласан. Уг зарласан тендерүүдээс өндөр өртөгтэй тоног төхөөрөмжийн тендер амжилтгүй болж төсвийн хэмнэлтийн тухай хуулиар ирэх оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулсан. Цахим дэлгүүрийн худалдан авах ажиллагааг холбогдох журам зааврын дагуу цаг тухай бүрт нь зарлан шалгарсан компаниудтай нь хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.	
3.14.	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;	Тайлант хугацаанд эрдэм шинжилгээний бага хурлаар 52 илтгэл хэлэлцүүлэгдэж 187 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж олон улсын хэмжээнд 5 илтгэл, улсын хэмжээнд 11 илтгэл хэлэлцүүлэгдсэн. Нийт 5 суурь судалгаа хийгдсэн. Хэлэлцүүлсэн илтгэлүүдийг “Анагаах увидас” сэтгүүлд эмхэтгэн 300 ширхгийг хэвлүүлж, эмч мэргэжилтнүүдийн гарын авлага болгон түгээсэн.	100
3.15.	Хууль тогтоомжид заасан бусад.	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.17-д... Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хяналт шалгалтын байгууллага хийсэн хяналт шалгалтынхаа дүнг эцэслэн гаргасны дараа ажлын 10 өдрийн дотор олон нийтэд нээлттэй болгоно.... заасны дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан 98 объект, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад 708 объект, хяналт шалгалтад нийт 806 объектын хяналт шалгалтын дүн, 20 аж ахуйн нэгж, 11 иргэн нийт 31 объектод 26.055,000 төгрөгний торгууль, хохирол нөхөн төлбөрийн шийтгэл оногдуулсан арга хэмжээ, 8 төрлийн шинжилгээний 936 дээж авч, шинжлүүлсэн сорилтын дүнгийн мэдээллийг шилэн хяналтын цахим системд бүртгэсэн. Засгийн газрын 2023 оны 195 дугаар тогтоолоор батлагдсан эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтээр хяналтын шалгалтын 5 чиглэлээр нийт 1067 объектод эрсдэлийн үнэлгээг хийж, шинээр байгуулагдсан 48, тусгай зөвшөөрлийн сэргээсэн 1 объектыг нэмэлтээр оруулж шилэн хяналтын системд 100 хувь бүртгэж, хяналт шалгалтын ил тод байдлыг бүрэн хангасан.	100
Хэсгийн дундаж хувь:87,3%			
Дөрөв.Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн			
4.1.	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;	ЭМДҮЗ-ын тогтоол, төлбөртэй тусламж үйлчилгээний журмын шинэчлэлт жагсаалтыг shilendans.gov.mn цахим хуудас болон www.orkhonboet.moh.gov.mn хуудас, самбарт байршуулсан. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах, хаяг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг www.or.mohs.gov.mn сайтын Тусгай зөвшөөрөл цэсэд нээлттэй байршуулсан. Тайлант хугацаанд 2026 оноос тусгай зөвшөөрөл бүхий байгууллагууд Etax програмаар дамжуулан license.mn цахим хаягт нэвтрэх бүх хүсэлтийг програмаар шийдвэрлэхээр бэлтгэл ажлыг ханган	100

		ажилласан.Улсын тэмдэгтийн хураамжийг аж ахуйн нэгж байгууллагууд Etax програмааар төлбөрийн мэдээлэл үүсгэж төлөлтийг хийсэн. Худалдаанд байгаа эмийн үнийг иргэдэд ил тод нээлттэй цахим хаяг em.hdc.gov.mn Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй нийтийн үйлчилгээтэй 2,830 эмийн сангийн хаяг болон зайлшгүй шаардлагатай эмийн 30 бүлгийн 120 нэр төрлийн 480 нэрийн эмийн үнэ эмийн сангуудад худалдаалж буй үнийн мэдээлэл харагдахуйц байршуулсан байдаг.Эрүүл мэндийн даатгалын үндэсний шинэчлэн батлагдсан тогтоолыг хэвлэмэл нэг төрлийн самбараар эмийн үнийг иргэдэд харагдахуйцаар байршуулан мэдээлэл өгч ажилласан.	
4.2.	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	Тусгай зөвшөөрлийн үйл ажллагаатай холбоотой журмыг баталсан Эрүүл мэндийн сайдын А/383, А/100 дугаар тушаал 2-р сарын 10-наар хүчингүй болж, Эрүүл мэндийн яамны төрийн нарийн бичгийн ирүүлсэн чиглэлийн дагуу Эрүүл мэндийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн хүрээнд тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг явуулан ажилласан. Тайлант хугацаанд Тусгай зөвшөөрлийн хурлыг нийт 11 удаа хуралдуулж 54 байгууллагын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд сунгалт 7, эрх сэргээлгэсэн 2, түдгэлзүүлсэн 7, хүчингүй болгосон 9, хаягийн шилжилт 5, төсөл 12, шинээр 16 байгууллагад зөвшөөрөл олгосон. Ажлын байранд 3-5 мэргэжилтний бүрэлдэхүүнтэй баг батлагдсан удирдамжийн дагуу 16 удаагийн үнэлгээг хийж, тусгай зөвшөөрлийн хурлаар дүгнэлтийг хэлэлцүүлж шийдвэрлэсэн. Эрүүл мэндийн газрын or.mohs.gov.mn сайтад тусгай зөвшөөрөл бүхий байгууллагын хаяг, мэдээлэл, 2025 оны хүчингүй болгосон, сунгасан, шинээр олгосон, хаягийн шилжилт, нэмэлт өөрчлөлтүүдийг батлан, Эрүүл мэндийн газрын даргын нийт 10 тушаалыг нээлттэй байршуулан мэдээллээр хангаж ажилласан.Мөн мэдээллийн нэгдсэн цахим license.mn программд 167 байгууллагын мэдээллийг байршуулсан.	100
Хэсгийн дундаж хувь: 100%			
Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
5.1.	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;	Эрүүл мэндийн ажилтны сурч хөгжих, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилготой “Хүн амын бүлэг, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөөнд эрүүл мэндийн салбарын ажилтнуудаас санал авч нэгтгэн боловсруулан аймгийн Засаг даргын 2025 оны А/86 дугаар захирамжаар батлуулан хэрэгжүүлсэн.	100
5.2.	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;	Эрүүл мэндийн салбарын хэмжээнд оюуны өмчийн эрхийг 2 чиглэлээр авсан бөгөөд цахим хуудаст байршуулан сурталчлан ажилласан. Үүнд: - БОЭТ-ийн Төгсөлтийн дараах сургалтын төслийн хүрээнд “Ерөнхий мэргэшил судлал” –аар “Сувилагч мэргэжлээр суралцагчдын шийдвэр гаргах чадварыг	100

		<p>хөгжүүлэх нь” зэрэг номуудад патент авсан.</p> <p>- Эрдэнэт сувиллын бага эмч Г.Цоодол нь “Парафин эмчилгээг зэстэй хослуулан хэрэглэсэн үр дүн”-ээр оюуны өмчийн эрх авсан байна.</p> <p>“Сувилагч мэргэжлээр суралцагчдын шийдвэр гаргах чадварыг хөгжүүлэх нь” зэрэг номд оюуны өмчийн эрхийг авсан бөгөөд цахим хуудаст байршуулан сурталчлан ажилласан. Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалтыг цахимд байршуулан ил тод байдлыг ханган сурталчлан ажилласан</p>	
5.3.	Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;	<p>2025 онд Аймгийн Газар зохион байгуулалтын төлөвлөлтөөр батлагдсан Эрүүл мэндийн салбарт 2 өрхийн эрүүл мэндийн төвийн газар шийдвэрлэгдэж, Үүнд:</p> <p>1.Цагаанчулуут багийн нутаг дэвсгэр дээр 3000 м2 талбайтай Өрхийн Эрүүл мэндийн төвийн барилга шинээр баригдахаар газрын нэгж талбарын 6104143670 дугаартай.</p> <p>2.Уртбулаг багийн нутаг дэвсгэр дээр 1250 м2 талбайтай Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга шинээр баригдахаар газрын нэгж талбарын 61033436161 дугаартай газрууд тус тус шийдвэрлэгдсэн.</p>	100
5.4.	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	<p>Эрүүл мэндийн харьяа байгууллагуудын газрын мэдээллүүдийг цахим системд оруулан шилэн дансанд байршуулан ажилласан. Эрүүл мэндийн газрын шилэн дансанд эрүүл мэндийн салбарын 11 барилгыг зураг, тооцооллын хамт байршуулан ил тод байдлыг хангасан.</p>	100
5.5.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;	<p>2025 оны эхний 12 сарын байдлаар Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Жаргалант сумын эрүүл мэндийн төв, 2024 оны төсөв 36,7 тэрбум төгрөг батлагдсанаас Эрүүл мэндийн газар 76,4 сая, БОЭТ нь 975,9 сая төгрөг, Жаргалант сумын эрүүл мэндийн төв нь 41,9 сая төгрөг, нийт 1.094,2 сая төгрөгийг татварын санд, Эрүүл мэндийн газар 113,1 сая, Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 2.247,4 сая төгрөг, Жаргалант сумын эрүүл мэндийн төв нь 45,5 сая төгрөг, нийт 2.406,0 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлэн төлсөн байна. 2024 оны 12 сарын байдлаар татвар болон нийгмийн даатгалын санд үүссэн өр төлбөр ЭМДЕГазраас авах авлагын дүнгээр барагдуулж ажиллана.</p>	100
5.6.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн	<p>Мөнхсүндрэл өрхийн эрүүл мэндийн төвийн даргыг Нөхөрлөлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу нөхөрлөлийн гишүүдийн олонхийн саналаар сонгон өрхийн эрүүл мэндийн төвийн даргаар томилсон.Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үйл ажиллагааны ил тод, үр ашигтай удирдлагыг хангах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан. Тайлант хугацаанд тус зөвлөл нийт 4 удаа хуралдсан бөгөөд үүнээс 2 удаагийн хурал цахимаар, 2 удаагийн хурал танхимаар зохион байгуулагдсан.</p> <p>ЭМС-ын 2021 оны А/414 дугаар тушаалын дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний</p>	100

	<p>удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;</p>	<p>төвийн захирлын нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хийж, зарлалыг 2025 оны 11 сарын 12–28-ны өдрүүдэд Эрүүл мэндийн яам болон Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулсан. Зарлалын дагуу сонгон шалгаруулалтын үйл явцыг зохион байгуулж, шаардлагын дагуу дүнг нэгтгэн Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн байна.</p> <p>ЭМГ-ын даргын 2025 оны 01 сарын 31-ний өдрийн “Удирдлагын зөвлөлийг шинэчлэн батлах тухай” А/11 дүгээр тушаалаар УЗ-ийг 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталсан. Тайлант хугацаанд 9 удаа хуралдаж 18 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Шийдвэрийн хэрэгжилт 95 хувь байна.</p>	
5.7.	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах талаар Аймгийн орон нутгийн өмчийн газраас ямар нэгэн шийдвэр гараагүй. Мөн төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалтаас гаргасан орлого, төсвийн хөрөнгийн ашиглалт болон ашиглалтаас гарсан захирамж, шийдвэр 2025 онд гараагүй байна.</p>	70
5.8.	<p>Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;</p>	<p>Аймгийн хэмжээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, хувийн хэвшлийн Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг, Талын булаг клиникт Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын МХЕГ-ын цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газраас тусгай зөвшөөрлийн дагуу рентген оношилгооны тоног төхөөрөмжүүдийг ашиглаж стандартын дагуу оношилгоог хийж ажилласан бөгөөд Боловсролын газрын цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газраас тусгай зөвшөөрлийн дагуу цөм болон цацрагийн хяналтын улсын байцаагч хяналт тавьж ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Бүсийн оношилгоо эмчилгээний төвд ангиографийн аппарат 1, компьютер томографийн аппарат 1, суурин дижитал рентген аппарат 3, зөөврийн рентген аппарат 3 - Талын булаг ор бүхий клиникт зөөврийн дижитал аппарат 1 - Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэгт суурин дижитал рентген аппарат 1 -Эрдэнэт медикал төрөлжсөн төв эмнэлэг суурин дижитал рентген аппарат 2, маммограммын аппарат 1 /одоогоор засвартай байгаа/ - Эрдэнэт сувилал цогцолбор суурин дижитал рентген аппарат 1 - Эрүүл мэндийн дэмжих төв суурин дижитал рентген аппарат 1 тус тус оношилгоо хийж ажилласан. Рентген цацрагтай холбоотой орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл бүртгэгдээгүй. <p>Тайлант хугацаанд аюултай болон эмнэлгийн хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр боловсруулж, устгах технологийг нэвтрүүлэх хүрээнд Бүсийн оношилгоо</p>	100

		эмчилгээний төв нь 2024 оны 11 дүгээр сараас эхлэн 211 м ² талбай бүхий тусгай зориулалтын байранд төвлөрсөн боловсруулалтын үйл ажиллагааг зохион байгуулж, LAC-6505SP автоклав болон 2024.12.06-нд суурилуулсан Sterilwave 100 төхөөрөмжийг ашиглан халдваргүйжүүлэлт, боловсруулах, устгалын технологийг бүрэн нэвтрүүлэн ажиллаж байна.Төхөөрөмжийг ашигласнаар 38.8 тонн, хурц үзүүртэй 11.6 тонн, эмгэг 2.7 тонн, эсэд хортой болон химийн 0.4 тонн хог хаягдлыг стандартад нийцүүлэн халдваргүйжүүлж устгаж, эмийн гаралтай 302.7 кг хаягдлыг устгах зөвшөөрөл бүхий байгууллагатай хамтран устгалд оруулсан нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, аюултай хог хаягдлын эрсдэлийг бодитойгоор бууруулах үр дүнтэй технологийн шийдэл болсон.	
5.9.	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;	Тайланд хугацаанд Эрүүл мэндийн салбарт шинээр барилга барьж ашиглалтанд ороогүй болно	-
5.10	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ байхгүй.	-
5.11	Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;	Байгууллагын or.mohs.gov.mn цахим хуудсанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу ил тод нээлттэй байршуулах мэдээллүүд байгууллагын эрхэм зорилго, зорилт, алсын хараа, үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилт, тэргүүлэх чиглэл, эрүүл мэндийн чиглэлээрх төрийн бодлого, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төрийн үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, хурал, сургалтын илтгэл, хичээлүүд, хууль, эрх зүй, цаг үеийн мэдээ мэдээлэл, эрүүл мэндийн статистик мэдээлэл, зөвлөгөө, шилэн данс, төсөв санхүү, хүний нөөцийн ил тод байдал зэрэг нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй нээлттэй өгөгдөл мэдээллүүдийг ил тодоор or.mohs.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт тухай бүр шинэчлэн байршуулж ажилласан.	100
5.12.	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;	Тайлант хугацаанд байгууллагын зардлаар суралцсан суралцагч байхгүй. “Кибер аюулгүй байдлыг хангах нь” сэдэвт сургалтыг Цагдаагийн байгууллагатай хамтран 2025 оны 4 дүгээр сарын 5-25-ны хооронд зохион байгуулж, 23 байгууллагын 35 гаруй ажилтан хамрагдсан. Сургалтаар цахим мэдээллийн хамгаалалт, хувийн мэдээллийн нууцлал, кибер халдлагын эрсдэл, ЭМБ-ын цахим бүртгэлийн системийн хамгаалалтын бодлогын талаар мэдлэг олгосон. Үр дүнд нь оролцогчдын кибер аюулгүй байдлын мэдлэг 40%-иар нэмэгдэж, 20 орчим байгууллага хамгаалалтын	100

		дэглэмээ шинэчилснээр мэдээллийн задралын эрсдэл буурч, ажилтнуудын хариуцлага дээшилсэн.	
5.13.	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл.	Тайлант хугацаанд 367 удаагийн сургалт сурталчилгаанд давхардсан тоогоор 41276 иргэнийг хамруулж, 33 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизэд, 5 удаагийн мэдээллийг FM радиогоор хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн. Хувь хүн, байгууллага, төрийн нууцаас бусад Нийтийн мэдээллийн тухай хууль, Шилэн дансны тухай хуульд заасан нээлттэй мэдээллүүдийг тухай бүр Эрүүл мэндийн газрын цахим хуудас байгууллагын www.or.mohs.gov.mn болон Шилэн дансны мэдээллийн цахим www.shilendans.gov.mn системд тухай бүр байршуулан ажилласан.	100
Хэсгийн дундаж хувь: 97,2			
Хэрэгжилтийн дундаж хувь: 95.5% /Үр дүнд хүрсэн/			

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

П.ХИШГЭЭ

ТАНИЛЦСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА

Ц.МӨНХЦЭЦЭГ